



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2024 оны 03 сарын 21 өдөр

Дугаар 116

Улаанбаатар хот

Хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 148 дугаар тогтоолын 1.6 дэх заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.1.2, 4.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Хан-Уул дүүргийн 2, 3 дугаар хорооны нутаг дэвсгэрт баригдсан дунд төвөгшилтэй ангилалтын Нэхмэлийн шар байр орчмын дахин барилгажуулах төслийн инженерийн шугам сүлжээний ажлын зураг төсөл, барилга угсралтын ажлын хүрээнд бий болсон нийт 1,294,567,281.00 (нэг тэрбум хоёр зуун ерэн дөрвөн сая таван зуун жаран долоон мянга хоёр зуун наян нэг) төгрөгийн балансын үнэ, 227,678,201.53 (хоёр зуун хорин долоон сая зургаан зуун далан найман мянга хоёр зуун нэг төгрөг тавин гурван мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийг хавсралтад заасны дагуу “Улаанбаатар дулааны сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Тавинбэх, “Улаанбаатар дулааны сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Г.Баярсайхан нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө хүлээлцэх бүртгэлд тусгах ажлыг холбогдох хууль тогтоомж журмын дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2024 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТЭСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132001283  
9-r huraldaan.docx



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
 2024 оны 03 дугаар сарын 21-ны өдрийн  
 №..... дугаар тогтоолын хавсралт

"УЛААНБААТАР ДУЛААНЫ СҮЛЖЭЭ" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХӨРӨНГӨД БҮРТГЭХ ХӨРӨНГИЙН  
 ТОВЧОО

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэх өртөг (төгрөг)	Барилга байгууламжийг ашиглалтад оруулсан огноо
1	Нэвтрэх суваг	2019	475,088,795.00	80,237,218.71	394,851,576.29	2021.05.20
2	Ган яндан /Ф350мм, Ф400мм/	2019	432,910,250.00	73,113,731.11	359,796,518.89	2021.05.20
3	Ганбөмбөлгөн хаалт	2019	80,291,000.00	22,600,429.63	57,690,570.37	2021.05.20
4	Цутгамал худаг-1	2019	306,277,236.00	51,726,822.08	254,550,413.92	2021.05.20
			1,294,567,281.00	227,678,201.53	1,066,889,079.47	
	Нийт дүн		(нэг тэрбум хоёр зуун ерэн дөрвөн сая таван зуун жаран долоон мянга хоёр зуун наян нэгэн төгрөг)	(хоёр зуун хорин долоон сая зургаан зуун далан найман мянга хоёр зуун нэг төгрөг тавин гурван мөнгө)	(нэг тэрбум жаран зургаан сая найман зуун наян есөн мянга далан есөн төгрөг дөчин долоон мөнгө)	